

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Албан бичгийн шийдвэрлэлт зохион байгуулсан тухай ажлын тайлан

(2025 оны 2 дугаар улирал)

2025 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2025 оны 2 дугаар улирлын байдлаар албан бичиг шийдвэрлэлтийг Архивын Ерөнхий газрын даргын 2016 оны А/89 дүгээр тушаалаар шинэчлэн найруулсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоол болон бусад холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулж, ажиллаж байна.

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирсэн бичгийг edoc цахим системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд төрийн байгууллагууд болон бусад харилцагч байгууллагуудаас ирсэн нийт 635 албан бичгийг бүртгэгдсэн байдлаар нь ангилж үзвэл:


- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн – 3
- Байгууллага дээр бүртгэгдсэн – 299
- Системээр бүртгэгдсэн – 333 албан бичиг байна.
-

Үүний 76 албан бичиг нь хариутай ба 73 албан бичгийг шийдвэрлэн холбогдох хариуг хүргүүлсэн, одоогор 3 албан бичиг судлагдаж байна.

Мөн хариугүй 559 албан бичгийн 549 бичгийг хугацаанд нь, 1 бичгийг хугацаа хэтэрч хаасан, 9 албан бичиг судлагдаж байна.

Ирсэн бичиг шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4,86 хоног байна.

Ирсэн бичгийн тоо ба шийдвэрлэлтийн зөрчлийн график үзүүлэлт:



Ирсэн бичгийг хуваарилалтаар нь авч үзвэл Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 178 бичиг буюу 28,03%, Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс 73 бичиг буюу 11,49%, Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс 29 бичиг буюу 4,54%, Хяналтын хэлтэс 355 бичиг буюу 55,9%-ийг хуваарилан авч шийдвэрлэн ажиллаж байна.

Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 487 албан бичиг боловсруулж, батлуулан харилцагч байгууллага болон иргэдэд хүргүүлсэн. Үүнээс:

Хариугүй 463 бичиг, хариутай 24 бичиг хүргүүлж, хариуг хугацаанд нь хүлээн авч ажиллаж байна.

Хамрах хугацаанд баримт боловсруулалтын зөрчил 1 бүртгэгдсэн.

Явуулсан нийт 487 албан бичгийн 31,62 хувийг Захиргаа төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, 56,67 хувийг Хяналтын хэлтэс, 3,49 хувийг Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс, 8,21 хувийг Газар тариалан, мал аж ахуйн хэлтсээс боловсруулан илгээсэн.

Мөн монгол хэлний тухай хуулийн дагуу байгууллагаас боловсруулан гарч буй албан бичгүүдийг үндэсний монгол бичгээр хөрвүүлэн, албан хэрэг хөтөлж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.БАЯНХУТАГ



ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН
Ж.ХАНДСАЙХАН